




Олон улсын болон эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн бага хуралд илтгэл хэлэлцүүлэв

11-р сарын 18-ны өдөр Мал эмнэлгийн хүрээлэн (МЭХ)-гийн 60 жилийн ойд зориулан цахимаар зохион байгуулагдсан Олон улсын бага хуралд BeeDep-MONGOL 2 төслийн менежер Акиёо Нишияма “Зөгийн аж ахуй ба орон нутгийн тогтвортой хөгжил” сэдвээр илтгэл тавилаа. Тус илтгэлд зөгийн аж ахуйн өвөрмөц байдал, BeeDep-MONGOL төслийн үйл ажиллагааны тойм, хачигтай тэмцэх механик аргын туршилт судалгаа зэрэг МЭХ-тэй хамтран хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, Монголын зөгийн аж ахуйн хөгжилд МЭХ-гийн гүйцэтгэх үүрэг гэх мэт сэдвүүд багтсан болно.

11-р сарын 23-ны өдөр МЭХ-гийн 60 жилийн ойд зориулан зохион байгуулагдсан эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн бага хуралд BeeDep-MONGOL 2 төслийн ажилтан Д.Ууганбаяр “Зөгийн аж ахуйд чиглэсэн мал эмнэлгийн үйлчилгээг хөгжүүлэх нь” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв. Энэхүү илтгэлд Зөгийн аж ахуйд мал эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуйн ерөнхий шаардлагыг хэрэгжүүлэх нийтлэг заавар, түүнийг хэрэгжүүлэх, байгууллага, мэргэжилтний чадавхийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа, туршилт судалгааны ажил зэрэг сэдвүүд багтсан юм.

BeeDep-MONGOL төсөлтэй идэвхитэй хамтран ажиллаж буй МЭХ-гийн дэргэдэх Зөгийн эрүүл мэнд, эм бэлдмэлийн судалгааны төв нь технологи хөгжүүлэх байдлаар Монголын зөгийн аж ахуйн ирээдүйн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах болно.



Хуралд илтгэл тавьж байгаа нь.

Акиёо Нишияма (дээд төв хэсэгт), Ууганбаяр (доод дунд хэсэгт)

Өвөлжилтөнд чиглэсэн туршилтын ажил явагдаж байна

Хавар зөгийн бүл өвөлжөөнөөс гарсны дараа хээлтэй эх зөгийгөөр дутагдах явдал Монголын зөгийн аж ахуйн хувьд томоохон бэрхшээл болдог билээ. Иймээс **эх зөгийг хээлтүүлгийн хайрцаг ашиглан бүлэнцэрт өвөлжүүлэх туршилтыг** төслийн багаас санаачлан Сэлэнгэ аймгийн Шаамар сум, Дархан-Уул аймгийн Орхон сум, Улаанбаатар хот зэрэг газруудад тус бүр нэг зөгийн аж ахуйтай хамтран хэрэгжүүлж байна.

Мөн зөгийн бүл **өвөлжих үеийн нэмэлт тэжээлийн туршилтыг** МЭХ-гийн дэргэдэх Зөгийн эрүүл мэнд, эм бэлдмэлийн судалгааны төвтэй хамтран хэрэгжүүлж байна. Зөгийн бүл өвөлжих явцдаа хорогдох шалтгаануудын нэг нь тэжээл дутах явдал байдаг. Иймээс бид Япон болон Монголын зарим зөгийчдийн туршлага дээр үндэслэн өвөлжилтөнд зориулсан нэмэгдэл тэжээл бэлтгэх болон ашиглах туршилтыг хэрэгжүүлж байна.

Туршилт бүрийн дүнг төслийн фэйсбүүк хуудсаар ирэх онд дэлгэрэнгүй танилцуулах болно.



(зүүн дээд) Өвөлжих үеийн нэмэгдэл тэжээлийн нэг болох сахарын кэнди хийж байна. Японоос Х.Хошиба багш хийх аргыг цахимаар харуулав.
(зүүн доод) Бэлэн болсон сахарын кэнди (баруун) Монголд явагдаж буй нэмэлт тэжээлийн

Төслийн Facebook :

www.facebook.com/BeeDep-MONGOL-2-107843977265085/?modal=admin_todo_tour

Онлайн семинарыг хүргэж байна !

